1.2	Эрчим хүч хэмнэлтийн тухай хуулийн 9.1.9.г, 9.1.9.е-д заасан журмуудыг батлуулах;	2023	Журмын төслүүдийг ЭГ-аар хэлэлцүүлж холбогдох шийдвэрийг гаргуулсан байна.	ЭХЯ, ЭХЗХ
1.3	Барилгын норм ба дүрэмд дулааны тоолуурыг суурилуулах, ашиглах асуудлыг тусгах;	2023	Орон сууц, олон нийтийн барилгын төлөвлөлтийн холбогдох норм, болон Хэмжил зүйн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай төслүүдийг боловсруулсан байна.	ЭХЯ, ЭХЗХ
1.4	Халаалтын зардал хуваарилах хэрэгслийг дулааны төлбөр тооцооны системд ашиглах эрхзүйн орчныг бүрдүүлэх;	2023	Хэрэглэгчийн эрчим хүчний хэрэглээний төлөвлөлт болон оргил ачааллын үеийн хэрэглээг бууруулах зохицуулалт гэрээнд туссан байна.	ЭХЗХ ТЗЭ
1.5	Эрчим хүчээр хангах гэрээний загвар болон аж ахуйн харилцааны дүрэмд эрчим хүчний хэмнэлтээр хэрэглээг бууруулах зохицуулалтыг тусгах;	2023	Хэрэглэгчийн эрчим хүчний хэрэглээний төлөвлөлт болон оргил ачааллын үеийн хэрэглээг бууруулах зохицуулалт гэрээнд туссан байна.	ЭХЗХ ТЗЭ
1.6	Эрчим хүчний хэмнэлт, үр ашгийг сайжруулахад шаардлагатай стандарт, норматив, техникийн зохицуулалтын баримт бичгийн жагсаалтыг гаргах, батлуулах, хэрэгжүүлэх ажлыг үе шаттай зохион байгуулах;	2023-2026	Шаардлагатай стандарт, техникийн зохицуулалт, нормативын баримт бичгийн судалгаа хийгдэж, холбогдох арга хэмжээ авсан байх.	ЭХЗХ ААТҮГ
1.7	Бусад шаардлагатай хууль, эрхзүйн зохицуулалтыг сайжруулах санал боловсруулж танилцуулах;	2023-2026	Шаардлагатай эрхзүйн зохицуулалтын баримт бичгийн судалгаа хийгдэж, холбогдох арга хэмжээ авсан байх.	ЭХЯ, ЭХЗХ ТЗЭ
2	Эрчим хүчний оргил ачааллын үеийн цахилгаан эрчим хүчний ачааллыг диспетчерийн зохицуулалтаар бууруулах хүрээнд:			
2.1	Эрчим хүч хэрэглэгчийн сайжруулж, аоригтот бүлэг бүртгэл, мэдээллийн системийг	2023-	Хэрэглэгчийг эдийн засгийн үйл ажиллагааны	ДҮТ

2.2	Айл өрхийн хэрэглээнд хэрэглээнээс хамаарсан та					
2.3	Түгээх, хангах тусгай зө ачааллын үеийн хэрэглээ гаргаж дотоод зохион байг салбарын үйлдвэр, компани бууруулах судалгаа хийж, бууруулах төлөвлөгөө гарг	2.6	Чадлын бууралт, хэмнэсэн эрчим хүчний хэмжээ, эдийн засгийн өгөөжийг тооцох, үр дүнг хэмжиж, баталгаажуулах;	2023-2026	Хөтөлбөрийн нэгдсэн үр дүн, хэмнэлт, үр ашгийн хүрсэн түвшинг жил бүр хэмжиж, тооцон баталгаажуулж, үр дүнг тайлагнаж тогтолцоо бүрдсэн байна.	ЭХҮТ ТӨХХК, ЭХЗХ ТӨҮГ
2.4	Бууруулах судалгаа хийж, бууруулах төлөвлөгөө гарг	2.7	Эрсдлийг үнэлэх, түүнийг бууруулах арга хэмжээг тодорхойлох;	2023	Хэрэглэгчдэд гарч болох эрсдлийг үнэлэн түүнээс хамгаалах, бууруулах боломж, арга замуудыг тодорхойлсон байна.	ЭХЗХ ТЗЭ ДҮТ
2.5	Эрчим хүч түгээх, хангах нэгдсэн системийг нэвтрүү	3	Эрчим хүчнийг зөв зохистой хэрэглэх сурталчилгааг хийх замаар эрчим хүчний хэрэглээг бууруулах хүрээнд:			
		3.1	Сурталчилгааны ажлыг хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөө, төсөв гаргаж хэрэгжүүлэх;	2023-2026	Нэгдсэн удирдлага, зохион байгуулалтын хүрээнд сурталчилгааны компани ажил өрнөж, үйл ажиллагаа тогтмолжсон байна.	ЭХЯ, ЭХЗХ, ДҮТ, ЭХҮТ, ТЗЭ
		3.2	Томоохон хэрэглээтэй эрчим хүч хэрэглэгч рүү чиглэсэн зарлан мэдээлэх систем бий болгож, хэрэгжүүлэх;	2023-2026	Оргил ачааллын цагт хэрэгцээгүй хэрэглээг мэдээлсэнээр хэрэглээ буурч үр дүнгээ өгсөн байна.	ДҮТ, ТЗЭ
		3.3	Оргил ачааллын үеийн хэрэглээг бууруулахад чиглэсэн сургалт, танин мэдэхүйн арга хэмжээг зохион байгуулах;	2023-2026	Эрчим хүчний салбарын ИТА болон хэрэглэгчид сургалт явуулж ойлголт өгсөн байна.	ЭХЗХ, ДҮТ, ТЗЭ

—000—

Эрчим хүчний сайдын 2023 оны А/119 тушаалаар дээрх удирдамж, ерөнхийг төлөвлөгөөг хэрэгжүүлэх нарийвчилсан арга хэмжээг баталсан. Тус төлөвлөгөөгөөр Эрчим хүчийг зөв зохистой хэрэглэх нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулах, сурталчлан таниулах арга хэмжээг нэгдсэн зохион байгуулалттайгаар хэрэгжүүлэх Ажлын хэсэг 4 үндсэн зорилтын хүрээнд 39 арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр тусгагдсан.



2023 оны 05 сарын 30 өдөр

Дугаар А/119

Улаанбаатар хот

Төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1. Эрчим хүчний сайдын 2023 оны А/51 дүгээр тушаалаар баталсан “Эрчим хүчний хэмнэлтээр хэрэглээг бууруулах” арга хэмжээний удирдамж, ерөнхий төлөвлөгөөний хүрээнд 2023-2026 оны өвлийн их ачааллын үеийн эрчим хүчний хэрэглээг бууруулах, хэрэгцээг удирдах хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2. Батлагдсан төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих, үр дүнг тухай бүр танилцуулж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Н.Тавинбэх/, Эрчим хүчний зохицуулах хорооны дарга /Э.Түвшинчулуун/, “Диспетчерийн үндэсний төв” ТӨХХК-ийн гүйцэтгэх захирал /Г.Балжинням/ нарт тус тус даалгасугай.

3. Батлагдсан төлөвлөгөөг хэрэгжүүлж, тайлагнаж ажиллахыг эрчим хүчний салбарын байгууллага, үйлдвэр, компаниудын дарга, гүйцэтгэх захирал нарт үүрэг болгосугай.

4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газрын дарга /Х.Бекболат/-д даалгасугай.





Б.ЧОЙЖИЛСҮРЭН



ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭМНЭЛТ, ҮР АШИГ - АВЧ ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ АРГА ХЭМЖЭЭ

Зорилго: Эрчим хүчийг зөв зохистой хэрэглэх нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулах, сурталчлан таниулах, хэрэглэгчдэд хэмнэх дадал хэвшил бий болгох замаар эрчим хүчний хэрэглээг бууруулах арга хэмжээг нэгдсэн зохион байгуулалттайгаар хэрэгжүүлэх;



Зорилт 3.1

Эрчим хүчний хэмнэлт, үр ашиг, оргил ачааллыг бууруулахад чиглэсэн сурталчилгааны ажлыг хэрэгжүүлэх;

93%

Зорилт 3.2

Эрчим хүчний өндөр хэрэглээтэй хэрэглэгчдэд зарлан мэдээлэх систем бий болгож, хэрэгжүүлэх;

59%

Зорилт 3.3

Хэмнэлт, үр ашиг, оргил ачааллын үеийн хэрэглээг бууруулахад чиглэсэн сургалт, танин мэдэхүйн арга хэмжээг зохион байгуулах;

72%

Зорилт 3.4

Үр дүнг тооцох, тайлагнах, урамшуулах ажлыг зохион байгуулах;

27%



ТОГ-ООН 17-22 цаг
ТӨХИРУУЛЪЯ
Нийгмийн нөлөөллийн аян



АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ, БИЕЛЭЛТ



СУРТАЛЧИЛГАА-14
Гүйцэтгэл-93%

1. Эрчим хүчний хэмнэлт, үр ашиг, оргил ачааллыг бууруулахад чиглэсэн сурталчилгааны ажлыг хэрэгжүүлэх



ЗАРЛАН МЭДЭЭЛЭХ СИСТЕМ-7
Гүйцэтгэл-59%

2. Эрчим хүчний өндөр хэрэглээтэй хэрэглэгчдэд зарлан мэдээлэх систем бий болгож, хэрэгжүүлэх

АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ-39
Гүйцэтгэл-63%

3. Эрчим хүчний хэмнэлт, үр ашиг, оргил ачааллын үеийн хэрэглээг бууруулахад чиглэсэн сургалт, танин мэдэхүйн арга хэмжээг зохион байгуулах



СУРГАЛТ ТАНИН МЭДЭХҮЙ-12
Гүйцэтгэл-72%

4. Үр дүнг тооцох, тайлагнах, урамшуулах ажлыг зохион байгуулах



ҮР ДҮН-6
Гүйцэтгэл-27%



“ТОГ-ОО ТОХИРУУЛЪЯ” НӨЛӨӨЛЛИЙН АЯН



ТОГ-ОО ТОХИРУУЛЪЯ

17-22 цаг
Нийгмийн нөлөөллийн аян

“Эрчим хүч ба хэвлэл мэдээлэл” сургалт 2024.01.01-31-ний хооронд


ЭХЗХ болон МЭХЗХ хамтран 210 контент үйлдвэрлэж олон нийтэд түгээсэн. 2,2 сая хүнд хүрсэн.

“Өөрчлөлтийг өөрөөсөө” нэгдсэн аяныг салбарын аяныг бүх компаниуд хэрэгжүүлж ДХЦЭХ-ний хэмжээг бууруулсан.

“Нэг дусал” радио контентын хүрээнд нийт 1100 дусал мэдээ 21 аймаг болон хүн ам ихтэй суурин газарт цацагдсан.

Хэрэглээгээ бууруулах, хэмнэх зөвлөмж бүхий масс мессежийг өвлийн оргил ачааллын саруудад түгээсэн.

ҮХХ, томоохон ААНБ-ууд өвлийн оргил ачааллын саруудад мэдээлэл түгээх аянд нэгдэж оролцсон



• Үүрэг хүлээсэн хэрэглэгч

- Эрчим хүчний салбар
- Аж үйлдвэр
- Барилга
- Бусад хэрэглэгч



МЭДЭЭЛЭЛ СУРТАЛЧИЛГААНЫ ЧИГЛЭЛЭЭР



Сурталчилгааны контент

- Нийт авсан гэрэл зураг 1,000
- Нийт постер контент 175
- Нийт видео контент 35

Гадаах сурталчилгаа (LED)

- Хугацаа: 23.12.04-24.02.08
- Давтамж: 1 өдөрт 70 удаа
- Секунд: 60 секунд

ТВ сурталчилгаа

- МҮОНРТ, Боловсрол ТВ,
- Moviebox, TV9 болон
- Бусад

Сошиал

- FB ПОСТ
- FB видео
- Reel
- Influencer

Вэб сайтын мэдээ, нийтлэл

- Ikon.mn, Ubn.mn
- Gogo.mn, бусад



Медиа, гадаа
сурталчилгаа
6.5 сая үзэлт

Видео контент

TOTAL IMPRESSION
~2,7 сая





МЭДЭЭЛЭЛ СУРТАЛЧИЛГАА - ОЛОН НИЙТЭД ТАНИУЛАХ ЧИГЛЭЛЭЭР

Эрчим хүчний авчирдаг ая тух, бүтээмжийг илэрхийлэх зорилгоор цахилгаан, дулааныг илэрхийлсэн хоёр төрлийн маскот дүр бүтээж загварыг гаргасан.

Эрчим хүчний зохицуулах хороо
5d · 🌐

"Эрчим хүчний шимэгч"-ийг тэжээлээс нь салгаж, хэмнэлттэй хэрэглээнд нэгдээрэй.
#ЭхОрончХэмнэлт
#Tog_ooТохируулья #TogХэрэглээнийСоёл

79
254 shares



Зурган контент

TOTAL IMPRESSION
3,3 сая

	Reach	Impression	Engagement	Reaction	Share
Creative post 1	18,992	22,259	1,226	345	148
Creative post 2	33,080	40,204	2,490	754	173
TVC print 1	58,464	61,224	206	20	23
TVC print 2	44,620	63,677	2,539	405	78
TVC print 3	253,942	519,756	15,795	2,119	430
TVC	668,100	852,899	3,400	2,400	778



ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН БАЙГУУЛЛАГА, СЭТГҮҮЛЧДЭД ЗОРИУЛСАН СУРГАЛТ



“Эрчим хүч ба хэвлэл мэдээлэл” сэтгүүлчид, эрчим хүчний байгууллагуудын хэвлэл мэдээллийн мэргэжилтнүүдийг чадавхжуулах сургалт зохион байгуулах




Хугацаа 2024.01.04 – 01.31


Сургалтын хэлбэр: 3 удаагийн танхимын сургалт, 1 удаагийн танилцах аялал

Оролцогчид: Хэвлэл мэдээллийн байгууллагын нийт 22 хүн

Сургалтын үр дүн: Эрчим хүчний чиглэлээр сэтгүүлчдийн болон салбарын мэргэжилтнүүдийн сүлжээг үүсгэх, эрчим хүчний талаар мэргэшсэн сэтгүүлчдийг бий болгох, чадавхжуулахад эхний суурь алхам болсон.





Олон нийтэд хүргэх мэдээллийн тоо, чанар дээшилсэн.



Үр дүн:

- Эрчим хүчний чиглэлээр мэдээлэл боловсруулах, түгээх, олон нийтэд хүргэх ажил эрчимжсэн.
- Эрчим хүчний салбарт шинэ сэтгүүлүүд төрөн гарсан.
- Хэвлэл мэдээллийн байгууллагын харааг чиглүүлж чадсан.
- Сэтгүүлчдийн мэдлэг мэдээлэл дээшилсэн





“ЗӨВ ХЭРЭГЛЭЖ-ЗӨНДӨӨ ХЭМНЭЭ” /2023.11.13-12.15/



Нийслэлийн 8 дүүргийн ерөнхий боловсролын нийт 170 сургуулиудын бага ангийн сурагчдын дунд **“Зөв хэрэглэж-Зөндөө хэмнэе”** аяныг зохион байгуулав.





СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГААНЫ АЖЛЫН ХҮРЭЭНД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ АРГА ХЭМЖЭЭ



Хэрэглэгч менежментийн боловсруулах, компаниудын бэхжүүлэх; талын хөтөлбөр салбарын чадавхыг

“Хэрэглэгч талын менежмент (Demand Side Management)”-ийн мэргэжилтэн бэлтгэх 5 өдрийн танхимын сургалтыг АНУ-ын ОУХА, МЭХЗХ дэмжиж Канад улсын Эрчим Хүчний Сургалтын Институт (Canadian Institute for Energy Training), эрчим хүчний зөвлөх фирм Econoleg-тай хамтран 5 өдрийн турш нийт 50 цагийн сургалтыг салбарын 30 мэргэжилтнийг хамруулсан.



ЕБС-ийн шинжлэх ухааны холбогдолтой хичээлийн агуулгад “Эрчим хүчний хэмнэлт, зохистой хэрэглээ” хичээлийг тусгуулах;

НБГ-тай хамтран 2024.2-р сард “**Эрчим хүч- зохистой хэрэглээ**” хичээлийн хөтөлбөрийн ололт, дутагдал, сайжруулах арга замыг тодорхойлох сургалтыг НЕБС-иудын сургагч багш нарын дунд зохион байгуулсан. Сургалтанд 11 сургуулийн нийт 27 сургагч багш оролцсон. Сургалтын агуулгад тусгуулахаар салбарын яаманд хандаад байна.



Салбарын ажилтнуудад эрчим хүчний хэмнэлт, үр ашиг, оргил ачааллыг бууруулах, техникийн мэдлэг олгох, чадавх бэхжүүлэх сургалт, зохион байгуулах;

Салбарын ИТА-ууд USAID-ийн Эрчим хүчний засаглал хөтөлбөрөөс зохион байгуулсан 4 удаагийн сургалтанд хамрагдсан. Мөн АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлагийн санхүүжилттэй Эрчим хүчний засаглал хөтөлбөрөөс зохион байгуулсан “**Эрчим хүчний үр ашиг, хэрэглэгч талын менежмент**” АНУ-ын туршлага судлах аялалд салбарын холбогдох чиглэлийн ажилтнууд 2023.10.16-27-ны өдрүүдэд хамрагдсан.



Эрчим хүчний хэмнэлттэй, байгальд ээлтэй ногоон технологи, цахилгаан хэрэгслийн талаар үзэсгэлэн, арга хэмжээ зохион байгуулах;

Тус заалтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “**Инновац, сэргээгдэх эрчим хүч, эрчим хүчний үр ашгийн олон улсын үзэсгэлэн, конференц**”-ийг эдгээр өдрүүдэд “Монголын эрчим хүчний засаглал хөтөлбөр”-ийн дэмжлэгтэйгээр” ЭХЯ, ЭХЗХ-ны санаачилгаар Нийслэлийн Инновац бизнес хөгжлийн газар, МҮХАҮТ болон салбарын холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулж байна.



Сэтгүүлчид, оюутнууд, цэцэрлэг, ЕБС, багш нар зэрэг зорилтот бүлгүүдэд чиглэсэн эрчим хүчний хэмнэлтийн төрөл бүрийн уралдаан зохион байгуулах;

ЭХЗХ нь НБГ-тай НЕБС-ийн бага ангийн сурагчдын дунд эрчим хүчийг зүй зохистой хэрэглэх, хэмнэх зөв хандлага, амьдралын зөв хэвшил дадлыг бий болгох, төлөвшүүлэх, эрчим хүч хэмнэх энгийн аргаас суралцах, сонирхлыг бий болгох зорилгоор “**Зөв хэрэглэж, зөндөө хэмнэе**” аяныг 2023.11.13- 2023.12.15-ны хооронд сургууль, дүүрэг, нийслэл гэсэн 3 үе шаттайгаар зохион байгуулж, НЕБ-ын **170 сургуулийн 190,000** орчим бага ангийн сурагчдыг хамрууллаа.



ДОНОР БАЙГУУЛЛАГУУДАЙ ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭМНЭЛТИЙН ЧИГЛЭЛЭЭР ХАМТРАН АЖИЛЛАЖ БУЙ ЧИГЛЭЛ



АХБ-ны Эрчим хүчний хэмнэлтийг дэмжих техникийн туслалцааны төсөл	ГОУХАН-ийн УБ хотын угсармал орон сууцны дулаан техникийн шинэчлэл төсөл	ГОУХАН-ийн “Just transition-ийг хэрэгжүүлэх эрхзүйн зөвлөгөө, шүүх байгууллагын чадавхыг сайжруулах төсөл	АНУ-ын ОУХА-ын санхүүжилттэй Монголын Эрчим хүчний засаглал хөтөлбөр
Төслийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ			
<ul style="list-style-type: none"> • Үүрэг хүлээсэн хэрэглэгчдэд эрчим хүчний гүйцэтгэлийн хамгийн бага стандартыг нэвтрүүлэх • Эрчим хүчний мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх компаниудын (ESCO) үйл ажиллагаа, тулгамдаж буй асуудлуудад үнэлгээ хийх, зөвлөмж өгөх 	<ul style="list-style-type: none"> • УБ хотын угсармал орон сууцнуудыг дуллалах төслийн хүрээнд хэмнэлтийн ажлын үр дүнд хэмнэсэн эрчим хүчний хэмжээг хэмжиж, тооцож, баталгаажуулах, хяналтын тогтолцоог бий болгох, • Барилгын эрчим хүчний үр ашиг, хэмнэлтийг дэмжих урамшууллын механизмыг нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх. 	<ul style="list-style-type: none"> • Эрчим хүч хэмнэлтийн тухай хууль эрх зүйн орчныг шинэчлэх • Хууль эрх зүйн шинэчлэлтэй холбоотой дагалдан гарах журам, зохицуулалтын орчныг сайжруулахад дэмжлэг үзүүлэх. 	<ul style="list-style-type: none"> • Эрчим хүчний аудитор, менежерийн сургалтын хөтөлбөрийг сайжруулах, шинэчлэх, олон улсын жишигт хүргэх, сургагч багшийг бэлтгэх, хүний нөөцийг чадавхжуулах • Эрчим хүчний хэрэглэгч талын менежмент хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх.




ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭМНЭЛТИЙН ЧИГЛЭЛЭЭР ЦААШИД АВАХ АРГА ХЭМЖЭЭ

Д/д	БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ОРЧНЫГ САЙЖРУУЛАХ
1	Эрчим хүч хэмнэлтийн тухай хуульд өөрчлөлт оруулах ажлын хэсгийг шинэчлэн байгуулах, холбогдох арга хэмжээг зохион байгуулах;
2	Ахуйн хэрэглэгчдийн оргил цагийн тариф, хэрэглээнээс хамаарсан тарифын шатлалыг нэмэгдүүлэх;
3	Дулааны тоолуурыг суурилуулах, ашиглах асуудлыг барилгын норм ба дүрэмд тусгах, халаалтын зардал хуваарилах хэрэгслийг дулааны төлбөр тооцооны системд ашиглах эрх зүйн орчныг бүрдүүлэх;
4	Эрчим хүчний хэрэглэгч талын менежментийг сайжруулах (Demand side management program) хөтөлбөр хэрэгжүүлэх;

Д/д	ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭМНЭЛТЭЭР ХЭРЭГЛЭЭГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЭХ
1	Зорилтот бүлгийн хэрэглэгчдийг нарийвчлан судлах, ачааллын менежмент хийх боломжийг тодорхойлох, хэрэглэгчийн хэрэглээний менежментийг сайжруулах;
2	Оргил ачааллын үеийн хэрэглээг бууруулах арга хэмжээнд оролцож үр дүн гаргасан хэрэглэгчдийг урамшуулах боломжийг судалж, хэрэгжүүлэх;
3	Хэрэглэгчдийн оргил ачааллыг бууруулахад чиглэсэн зарлан мэдээлэх системийг хэрэгжүүлэх сайн туршлагыг судалж, нэвтрүүлэх;
4	“Тог-оо тохируулъя 17-22” нийгмийн нөлөөллийн аяны хэрэгжилтийн үр дүнг үнэлж, цаашдын алхамыг тодорхойлох, нөлөөллийн аяныг олон нийтийн оролцоог ханган үр дүнтэй зохион байгуулах;
5	“Эрчим хүчний хэмнэлтээр хэрэглээг бууруулах” арга хэмжээний хүрээнд 2024-2025 оны өвлийн их ачааллын үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний бэлтгэлийг хангах, ажлын хэсгийн төлөвлөгөөг нарийвчилж нэгдсэн зохион байгуулалттай хэрэгжүүлэх;

АНХААРАЛ ХАНДУУЛСАНД БАЯРЛАЛАА.



<http://erc.gov.mn>

<http://ecc.erc.gov.mn>

ХЭРЭГЛЭГЧИЙН СЭХ-НИЙ ҮҮСГҮҮРЭЭС ҮЙЛДВЭРЛЭСЭН ЭРЧИМ ХҮЧИЙГ ТҮГЭЭХ СҮЛЖЭЭНД НИЙЛҮҮЛЭХ ЖУРАМ



МОНГОЛ УЛСЫН
ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙДЫН
ТУШААЛ

2020 оны 08 сарын 14 өдөр

Дугаар 159

Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах тухай

Сэргээгдэх эрчим хүчний тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3.5 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1.Хэрэглэгчийн сэргээгдэх эрчим хүчний үүсгүүрээс үйлдвэрлэсэн эрчим хүчийг түгээх сүлжээнд нийлүүлэх журмыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

2.Энэ журмыг хэрэгжүүлж, хяналт тавьж ажиллахыг Эрчим хүч, түлшний бодлогын хэрэгжилтийн газар /Б.Насантогтох/-т даалгасугай.

3.Журам шинэчлэн баталсантай холбогдуулан Эрчим хүчний сайдын 2020 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн 95 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.



Н.ТАВИНБЭХ

170600355

Эрчим хүчний сайдын
2020 оны 08 дугаар сарын 14-ны өдрийн
95 дугаар тушаалын хавсралт

ХЭРЭГЛЭГЧИЙН СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧНИЙ ҮҮСГҮҮРЭЭС ҮЙЛДВЭРЛЭСЭН ЭРЧИМ ХҮЧИЙГ ТҮГЭЭХ СҮЛЖЭЭНД НИЙЛҮҮЛЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэ журмаар иргэн, хуулийн этгээд (цаашид “хэрэглэгч” гэх)-ийн сэргээгдэх эрчим хүчний үүсгүүрийг түгээх сүлжээнд холбох, хэрэглээнээс илүү гарсан цахилгаан эрчим хүчийг түгээх сүлжээнд нийлүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулна.

1.2. Хэрэглэгчийн сэргээгдэх эрчим хүчний үүсгүүр (цаашид “үүсгүүр” гэх) нь цахилгаан түгээх сүлжээнд холбогдоход дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

1.2.1.суурилагдсан хүчин чадал нь энэ журмын 3.1-д заасан хүчин чадлын хязгаарын хүрээнд багтсан байх;

1.2.2.Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрмийн 2 дугаар зүйл болон энэ журмын 1.2.3-т заасан техникийн шаардлагыг хангасны үндсэн дээр түгээх тусгай зөвшөөрөл эзэмшигч (цаашид “ТТЗЭ” гэх)-ээс бага оврын үүсгүүр суурилуулах тухай техникийн нөхцөл авсан байх;

1.2.3.ТТЗЭ-ийн сүлжээнд аюулгүй, зэрэгцээ ажиллах нөхцлийг хангаж, Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрэм, Цахилгаан техникийн байгууламжийн угсралтын дүрэм, Цахилгаан техникийн байгууламжийн угсралтын аюулгүй ажиллагааны дүрэм болон барилгын стандарт, норм ба дүрэм, өгөгдсөн техникийн нөхцлийн шаардлагыг бүрэн хангасан байх;

1.2.4.хэрэглэгч нь чадлын хоёр урсгалыг тусад нь тоолж, эрчим хүчний төлбөрөө тооцоолох;

1.2.5.төлөвлөгөөт засвар үйлчилгээ болон төлөвлөгөөт бус тасралтаас үүдэн цахилгаан түгээх сүлжээ рүү холбогдсон цэгт хүчдэл тасрах үед үүсгүүр нь цэнэг хуримтлууртай бие дааж ажиллах боломжтой тохиолдолд цахилгаан түгээх сүлжээнээс бүрэн тусгаарлагдах автомат таслуурыг өөр дээрээ суурилуулсан байх;

1.2.6.дэнэг хуримтлуурын төхөөрөмжгүй үүсгүүрийн хувьд цахилгаан түгээх сүлжээ рүү холбогдсон цэгт сүлжээ талаас хүчдэлгүй болмогц үүсгүүрийн үйл ажиллагаа бүрэн зогсох буюу гэдэрэг хүчдэл өгөхгүй байх техникийн шаардлагыг бүрдүүлсэн байх;

1.2.7.үүсгүүр нь холбогдох шаардлагад нийцсэн бие даасан өөрийн газардуулах байгууламжтай байх;

1.2.8.үүсгүүрт сэргээгдэх эрчим хүчний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг итгэмжлэгдсэн лабораториар хэмжилт хийлгэж, тохирлын үнэлгээнд хамрагдсан байх.

1.3. Энэ журмыг мөрдөж эхлэхээс өмнө суурилагдсан үүсгүүр нь энэ журмын 1.2-т заасан шаардлагыг хангасан байхын зэрэгцээ бага оврын үүсгүүрийн техникийн нөхцөл авч түгээх сүлжээнд холбогдоно.

Хоёр. Талуудын эрх, үүрэг

2.1. Эрчим хүчний асуудал эрхэлсэн торийн захиргааны төв байгууллага нь дараах эрх, үүрэгтэй байна. Үүнд:

2.1.1.тухайн жилд түгээх сүлжээнд холбогдох боломжтой үүсгүүрийн хүчин чадлын нарийвчилсан төлөвлөгөөг энэ журмын 2.3.4-т заасан судалгаанд үндэслэн батлах.

2.2. Эрчим хүчний зохицуулах хороо нь дараах эрх, үүрэгтэй байна. Үүнд:

2.2.1.хэрэглэгчийн үүсгүүрээс түгээх сүлжээнд нийлүүлсэн цахилгаан эрчим хүчний тариф тогтоох, холбогдох асуудлыг зохицуулсан аргачлал боловсруулж, батлах;

2.2.2.тухайн жилд холбох боломжтой бага оврын үүсгүүрийн нийлбэр хүчин чадлын дээд хэмжээг ТТЗЭ тус бүрээр тогтоох.

2.3. ТТЗЭ нь дараах эрх, үүрэгтэй байна. Үүнд:

2.3.1.хэрэглэгчийн үүсгүүрийг түгээх сүлжээнд холбоход Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрмийг мөрдөх;

2.3.2.бага оврын үүсгүүрийг холбуулах хүсэлтийг судлан энэ журмын 2.2.2-т заасан хэмжээг үндэслэл болгож тухайн хэрэглэгчийн үүсгүүрийн боломжит чадлыг тогтоож, техникийн нөхцөл олгох;

2.3.3.энэ журмын 1.2-т заасан шаардлагыг хангасан хэрэглэгчийн хүсэлтийг огнооны дарааллаар бүртгэлжүүлэх;

2.3.4.энэ журмын 2.2.2-т заасан хязгаарын хүрээнд өөрийн эзэмшлийн түгээх сүлжээний хүрээнд холбуулах боломжтой дэд станцын судалгааг гаргаж, эрчим хүчний асуудал эрхэлсэн торийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх;

2.3.5.сэргээгдэх эрчим хүчний тоног төхөөрөмжийн техникийн аюулгүй ажиллагаа, сүлжээ рүү гэдэрэг хүчдэл өгөхгүй байх нөхцөл, техникийн нөхцлийн шаардлагыг хангасан эсэхийг тогтоох зорилгоор сүлжээнд холбохын өмнө техникийн мэргэжлийн комисс ажиллуулах;

2.3.6.түгээх сүлжээнд засвар үйлчилгээ хийх зорилгоор хэрэглэгчийг хүчдлээс чөлөөлөх шаардлагатай тохиолдолд энэ тухай хэрэглэгчид 24 цагийн өмнө урьдчилан мэдэгдэх;

2.3.7.түгээх сүлжээнд холбогдсон үүсгүүрийн мэдээллийг жил бүр гаргаж, Диспетчерийн үндэсний төв болон холбогдох бусад газруудад хүргүүлэх;

2.3.8.түгээх сүлжээнд хэрэглэгчийн үүсгүүрийг холбоход шаардагдах баримт бичгийн жагсаалтыг өөрийн байгууллагын цахим хуудсанд байршуулах;

2.3.9.хэрэглэгчийн үүсгүүрийг түгээх сүлжээнд холбоход хүсэлт судлах, техникийн нөхцөл олгох, техникийн нөхцлийн дагуу холбох үйлчилгээ үзүүлэх төлбөрийг иргэн, хуулийн этгээдээс авах;



ХЭРЭГЛЭГЧИЙН СЭХ-НИЙ ҮҮСГҮҮРЭЭС ҮЙЛДВЭРЛЭСЭН ЭРЧИМ ХҮЧИЙГ ТҮГЭЭХ СҮЛЖЭЭНД НИЙЛҮҮЛЭХ ЖУРАМ

2.3.10.хэрэглэгчтэй байгуулсан Цахилгаан эрчим хүчээр хангах гэрээнд энэ журмын хүрээнд өөрчлөлт оруулах, өөрчлөлтийг цуцлах;

2.3.11.болзошгүй осол, авариаас урьдчилан сэргийлэх зорилгоор урьдчилан мэдэгдэхгүйгээр хэрэглэгчийн үүсгүүрийг сүлжээнээс салгах.

2.4. Хэрэглэгч нь дараах эрх, үүрэгтэй байна. Үүнд:

2.4.1.энэ журмаар тогтоосон суурилагдсан хүчин чадлын хязгаарт багтсан үүсгүүрийг суурилуулах;

2.4.2.олон улсын IEC61730-1, IEC61730-2 стандартын шаардлага хангасан нарны цахилгаан эрчим хүчний үүсгүүр, IEBE1547/IEC61000-3-15/IEC62116 стандартын шаардлага хангасан инвертерийг тус тус суурилуулах;

2.4.3.өөрийн хэрэглээнээс илүү гарсан эрчим хүчийг түгээх сүлжээнд нийлүүлэх;

2.4.4.цахилгаан эрчим хүчний оргил ачааллын үед эрчим хүчийг түгээх сүлжээнд нийлүүлэх зорилгоор үүсгүүрийг цэнэг хураагууртай суурилуулж болох бөгөөд энэ тохиолдолд 3 шатлалт тарифт тоолуур ашиглах;

2.4.5.Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөж байгаа MNS 1778:2007 үндэсний стандартын шаардлагыг хангасан цахилгаан эрчим хүчийг түгээх сүлжээнд нийлүүлэх;

2.4.6.түгээх сүлжээ талаас хүчдэлгүй болсон тохиолдолд үүсгүүрээс түгээх сүлжээ рүү хүчдэл өгөхгүй байх техникийн болон зохион байгуулалтын арга хэмжээг авах;

2.4.7.энэ журмын 2.4.6-д заасан арга хэмжээний зардлыг дангаараа хариуцах;

2.4.8.түгээх сүлжээ талаас хүчдэлгүй болсон тохиолдолд ТТЗЭ-ийн зөвшөөрөлгүйгээр үүсгүүрээс хүчдэл өгснөөс үүдэж аливаа этгээдэд учирсан осол, авариа, хохирлыг дангаараа хариуцах;

2.4.9.энэ журамд заасан техникийн шаардлага хангасан үүсгүүр, инвертер, тоолуур болон бусад дагалдах төхөөрөмжийг худалдан авах, суурилуулах, түгээх сүлжээнд холбогдоход гарах зардлыг бүрэн хариуцах;

2.4.10.үүсгүүрээс холболтын цэг хүртэлх тоноглолын аюулгүй ажиллагаа, засвар үйлчилгээ, гэмтэл, саатлыг засварлах зардлыг хариуцаж, ашиглалт, аюулгүй ажиллагаатай холбоотой тэдгээрээс үүдэн гарах хариуцлагыг хүлээх;

2.4.11.байгаль орчинд сөрөг нөлөө бүхий тоног төхөөрөмжүүдийн ашиглалтын хугацаа дууссан тохиолдолд зохих байгууллагад мэдэгдэж, Хог хаягдлын тухай хуулийн дагуу арга хэмжээ авч шийдвэрлэх.

2.5. Хэрэглэгч нь энэ журмын 2.4.9-д заасан тоног төхөөрөмжийн угсралт, засвар, үйлчилгээг тусгай зөвшөөрөл (ТЗ-1.1 болон түүнээс дээш)-тэй хуулийн этгээдээр гүйцэтгүүлнэ.

2.6. Диспетчерийн үндэсний төв нь нэгдсэн сүлжээний горим, тооцоо, реле хамгаалалт, автоматикийн тооцоог хийхдээ хэрэглэгчийн бага оврын үүсгүүрээс түгээх сүлжээнд нөлөөлөх нөлөөллийг харгалзан үзнэ.

Гурав. Үүсгүүрийн хүчин чадал, техникийн шаардлага

3.1. Хэрэглэгч нь дараах хүчин чадлын хязгаарын хүрээнд өөрийн эрчим хүчний хэрэглээний хязгаарт багтааж үүсгүүр суурилуулах боломжтой. Үүнд:

Хэрэглэгчийн ангилал	Хүчин чадал /кВт/
Иргэн	20 хүртэл
Хуулийн этгээд	техник нөхцлөөр тогтоосон чадлын 50 хувиас хэтрэхгүй

3.2. Хэрэглэгч нь үүсгүүрийг зөвхөн өөрийн хэрэгцээнд ашиглах зорилгоор түгээх сүлжээнээс тусгаар бие даасан хэлбэрээр ажиллуулж болно.

3.3. Бүх үүсгүүр түгээх сүлжээний 0.4 кВ-ын хүчдлийн түвшинд холбогдоно.

3.4. Үүсгүүрээс түгээх сүлжээний холболтын цэг хүртэлх шугаманд тавигдах хамгаалах хэрэгслийн тавил тооцоог ТТЗЭ-д бүртгүүлнэ. Шаардлагатай тохиолдолд реле хамгаалалт, автоматикийн сонголт, тавилын тооцоог ТТЗЭ-ээр гүйцэтгүүлнэ.

3.5. ТТЗЭ нь үүсгүүрээс нийлүүлэх эрчим хүчний чанарт энэ журмын 2.4.5-д заасан стандартын шаардлага хангаж байгаа эсэх талаар хараат бусаар дүн шинжилгээ хийлгэх, зөрчилтэй тохиолдолд стандартын шаардлагыг хангуулах арга хэмжээ авна.

Дөрөв. Цахилгаан эрчим хүчээр хангах гэрээнд өөрчлөлт оруулах

4.1. ТТЗЭ нь иргэн, хуулийн этгээдтэй байгуулсан Цахилгаан эрчим хүчээр хангах гэрээнд хэрэглэгчийн үүсгүүрээс үйлдвэрлэсэн цахилгаан эрчим хүчийг түгээх сүлжээнд нийлүүлдэгтэй холбоотой зохих өөрчлөлтийг оруулна.

4.2. Энэ журмын 4.1-д заасан гэрээнд дараах асуудлыг тусгана. Үүнд:

4.2.1.үүсгүүрийн туршилт;

4.2.2.хэрэглэгчийн нийлүүлэх цахилгаан эрчим хүчний хэмжээ;

4.2.3.энэ журмын 2.2.1-д заасан аргачлалтын дагуу хэрэглэгчийн нийлүүдсэн цахилгаан эрчим хүчийг хэрэглэсэн цахилгаан эрчим хүчээс хасч тооцох нөхцөл;

4.2.4.техникийн нөхцөл;

4.2.5.баглагдсан ажлын зураг;

4.2.6.техникийн комиссын акт;

4.2.7.үүсгүүрийн ашиглалт, засвар;

4.2.8.тоолуур, хэмжих хэрэгсэлд тавигдах шаардлага;

4.2.9.реле хамгаалалт, автоматикийн төхөөрөмж;

4.2.10.холбогдох бусад асуудал.

4.3. Цахилгаан эрчим хүчээр хангах гэрээнд өөрчлөлт оруулсны дараа иргэн, хуулийн этгээд нь сэргээгдэх эрчим хүчний үүсгүүрээс өөрийн хэрэглээнээс илүү гарсан эрчим хүчийг түгээх сүлжээнд нийлүүлэх, хэрэглэх эрхээр хангагдана.

4.4. Гэрээг аль нэг тал нь хүчингүй болгохоос бусад тохиолдолд гарын үсэг зурж баталгаажуулснаас хойш иргэнтэй 3 жил, хуулийн этгээдтэй 5 жилийн хугацаатай байгуулна.

Тав. Хяналт, хариуцлага

5.1. Энэ журмын биелэлтэд эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, мэргэжлийн хяналтын байгууллага, сэргээгдэх эрчим хүчний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн өмчит мэргэжлийн байгууллага, ТТЗЭ хяналт тавина.

5.2. Үүсгүүрээс инвертерийн гаргалгаа хүртэлх угсралт, суурилуулалтын ажилд сэргээгдэх эрчим хүчний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн өмчит мэргэжлийн байгууллага, ТТЗЭ тус тус хяналт тавьж ажиллана.

5.3. Энэ журмыг зөрсөн гэм буруутай этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ. Гэм буруутай этгээдэд эрүүгийн болон захиргааны хариуцлага хүлээлгэсэн эсэхийг үл харгалзан учруулсан хохирлыг нөхөн төлүүлнэ.

5.4. Талууд хоорондоо зөвшилцөн шийдвэрлэж чадаагүй цахилгаан эрчим хүчний хангамж, хэрэглээтэй холбогдсон маргааныг Эрчим хүчний зохицуулах хороо шийдвэрлэнэ. Энэ шийдвэрийг эс зөвшөөрвөл шүүхэд гомдлоо гаргана.

---ooOoo---